



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

УУЛ УУРХАЙН САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

Аудитыг дуусвар болгосон тухай тайлан

АГУУЛГА

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:

САГ-ын дарга: С.Энхзаяа
Утас: 261663

Аудитын менежер:
С.Оюунгэрэл
Утас: 260512

Аудитор: П.Чанцалдулам
Утас: 261740

Монгол Улсын Үндэсний аудитын газар

Монгол Улс
Чингэлтэй дүүрэг
Бага тойруу
Засгийн газрын IY байр

Цахим хуудас: www.audit.mn

Оршил
Санхүүгийн дотоод хяналт
Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
Аудитын санал дүгнэлт

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийгдсэн санхүүгийн
нэгтгэсэн тайлан

Хавсралт 4: Жилийн төсвийн гүйцэтгэлийн
нэгтгэсэн тайлан

Оршил

Уул уурхайн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитыг дуусвар болгосон тухай энэхүү тайланг танилцуулж байна. Менежментийн захидалд санхүүгийн зарим үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Сайдын багцын 2013 оны төсөвт зардал 22,035.1 сая төгрөгөөр батлагдсанаас 20,055.5 сая төгрөгийг зарцуулж, 1,979.6 сая төгрөг зарцуулагдаагүй байна.

Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл **15,597.9** сая, тайлант хугацаанд үйл ажиллагааны орлого 246,873.6 сая, валютын ханшийн олз 3,287.8 сая, нийт **250,161.4** сая төгрөгийн орлого орж, урсгал зардал 256,927.0 сая, хөрөнгө оруулалтын зардал 7,210.3 сая, санхүүгийн үйл ажиллагааны зардал 3.4 сая, нийт **264,140.7** сая төгрөгийн зарлага гарч, оны эцэст **1,618.6** сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2013 оны Төсвийн тухай хуулиар өөрийн орлогын төлөвлөгөөг 208,038.7 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр 220,362.7 сая төгрөгийн орлого олж, 105.9 хувийн биелэлттэй гарсан ба орлогын төлөвлөгөөг 12,324.0 сая төгрөг буюу 5.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Өөрийн орлогын гүйцэтгэлийн талаар : Нийт өөрийн орлого гүйцэтгэлээр 12,324.0 сая төгрөгөөр давсан нь үндсэн үйл ажиллагааны орлого 13,757.7 сая төгрөгөөр давуулан биелж, үндсэн бус үйл ажиллагааны орлого 1,433.7 сая төгрөгөөр тасарсантай холбоотой байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын талаар:

/сая.төг/				
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Экспортын орлого	161,721.3	175,077.9	13,356.6
2	БХГ-ний орлого		2,392.4	2,392.4
3	Газрын тосны газрын дүн	161,721.3	177,470.3	15,749.0
4	Хайгуулын болон тусгай зөвшөөрлийн орлого	38,400.3	35,706.6	(2,693.7)
5	Нөхөн төлбөрийн орлого	1,668.8	2,367.2	698.4
6	Ашигт малтмалын газрын дүн	40,069.1	38,073.8	(1,995.3)
7	Харьяа төсөвт байгууллагын өөрийн орлого	5.3	9.3	4.0
	Нийт дүн	201,795.7	215,553.4	13,757.7

2013 оны гүйцэтгэлээр өөрийн орлогын төлөвлөгөө Газрын тосны газар 15,749.0 сая, харьяа төсөвт байгууллага 4.0 сая төгрөгөөр тус тус давуулан биелсэн бол Ашигт малтмалын газар 1,995.3 сая төгрөгөөр тасарчээ.

Ашигт малтмалын газрын орлого тасарсан шалтгаан нь тайлант онд Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгохыг хориглох тухай хууль, Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сав бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиудтай холбоотой 234 тусгай зөвшөөрлийг цуцалж, 249 тусгай зөвшөөрлийг дуусгавар болгосон, мөн кадастрын сунгалт хийх үйлчилгээний байгууллагын тоо 2012 онд 555 ААН байсан бол 2013 онд 279 ААН болж буурсан, тусгай зөвшөөрлийн

шилжилт хөдөлгөөнийг 2012 оны 12 сарын 28-ны өдрөөс зогсоосон зэргээс шалтгаалан орлого тасарсан байна.

2013 оны Төсвийн тухай хуулиар улсын төсөвт төвлөрүүлэх орлого 208,033.4 сая, өөрийн үйл ажиллагаанд зарцуулах эрх 5.3 сая, нийт 208,038.7 сая төгрөгийн өөрийн орлогын төлөвлөгөөг баталснаас гүйцэтгэлээр 230,755.0 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2013 онд өөрийн орлогоос Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 22,721.6 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар:

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	/сая.төг/	
			Гүйцэтгэл	Зөрүү
1	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	164,421.3	191,159.6	26,738.3
2	Газрын тосны газрын дүн	164,421.3	191,159.6	26,738.3
3	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	43,612.1	39,595.4	(4,016.7)
4	Ашигт малтмалын газрын дүн	43,612.1	39,595.4	(4,016.7)
	Нийт дүн	208,033.4	230,755.0	22,721.6

Газрын тосны газар нь улсын төсөвт 191,159.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн ба үүнээс тайлант хугацааны орлого 180,752.5 сая, өмнөх оны мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс 10,407.1 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Ашигт малтмалын газар нь тайлант хугацаанд 39,600.8 сая төгрөгийн орлого олсноос 39,595.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 0.1 сая төгрөгийн бодит бус ханшийн олз үүсч, 5.3 сая төгрөгийг төсөвт дутуу төвлөрүүлсэн байна.

Ашигт малтмалын газрын дутуу төвлөрүүлсэн 5.3 сая төгрөгийг оны эцэст Сангийн яам татан төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын зардалд 11,843.8 сая төгрөг батлагдсанаас 10,581.8 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон ба зарцуулагдаагүй үлдэгдэл 1,262.0 сая төгрөг байна.

Хөрөнгө оруулалтад олгогдсон санхүүжилтийн 63.8 хувь буюу 6,756.1 сая төгрөгийг геологи судалгааны ажлын зардалд, 23.2 хувь буюу 2,452.7 сая төгрөгийг зураг төсөв хийхэд, барилга байгууламжийн өргөтгөлд, 10.8 хувь буюу 1,144.1 сая төгрөгийг тоног төхөөрөмж авахад, 2.2 хувь буюу 228.9 сая төгрөгийг их засварт тус тус зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө оны эхэнд 16,509.2 сая, тайлант хугацаанд 11,739.7 сая төгрөгөөр нэмэгдэж, 3,938.2 сая төгрөгөөр хасагдаж, оны эцэст 24,310.7 сая төгрөгийн хөрөнгөтэй байна. Үндсэн хөрөнгө бэлтгэх, худалдан авах, бусад шилжилт хөдөлгөөний ажил гүйлгээ нь холбогдох хууль, журмын дагуу явагдсан байна.

Уул уурхайн сайдын төсвийн багцад хамрагддаг 4 төсвийн шууд захирагч нар аудитад бүрэн хамрагдсан ба нийт төсөвт зардлын 97.5 хувийг Үндэсний аудитын газар, 2.5 хувийг Гэрээт аудитын компани тус тус хамарч санхүүгийн тайланд аудит хийсэн байна.

Аудитад хамрагдсан 4 салбар, нэгжийн 3 нь “Зөрчилгүй”, 1 нь сайдын төсвийн багцад түүврээр хамрагдсан болно.

Санхүүгийн дотоод хяналт

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс санхүүгийн хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Ийнхүү дахин хянахдаа Төсвийн ерөнхийлөн захирагчийн хяналтыг санхүүгийн эрсдэл ба хяналтын талаарх өөрийн мэдээллийн сантай харьцуулан шинжилгээ хийсэн.

Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах боломж олгосон.

Аудитын явцад дотоод хяналтыг үнэлэхэд: 2013 оны Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжууд болон Засгийн газрын шийдвэр, Сангийн яамнаас гаргасан заавар, журмын хэрэгжилт хангалттай байна.

Аудитаар дээд түвшний хяналтын асуудал хөндөгдсөн бөгөөд тэдгээрийг удирдлагын анхааралд хандуулж байна. Үүнд:

Төсвийн шууд захирагч нарын 2013 оны санхүүгийн тайланд хийгдсэн аудитын талаар:

Аудитаар нийт 28,694.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсний 52.7 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага бичигдсэн, 224.4 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгөгдсөн, 28,417.0 сая төгрөгийн 3 алдаанд залруулга хийгдсэн байна.

Аудитаар илэрсэн бүх асуудлыг тус байгууллагын удирдлага болон дотоод аудитын нэгж авч үзэж, судлан шийдвэрлэх шаардлагатай ба аудитын явцад илрүүлсэн алдааг үйлчлүүлэгч байгууллага хүлээн зөвшөөрч, залруулга хийгдсэн байна.

2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Газрын тосны газар нь Төрийн банкин дахь Сургалтын урамшууллын болон Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөс 157.2 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.
- Газрын тосны газрын Төлөөлөгчийг дэмжих сангийн тайланд 49.6 сая төгрөгийн зарлага илүү, Мөнгөн гүйлгээний тайланд 28,323.5 сая төгрөгөөр зарлага дутуу тайлагнагдсан нь санхүүгийн програм алдаатай илэрхийлэгдсэнтэй холбоотой ба аудитын явцад залруулах бичилт хийгдсэн.
- Газрын тосны газар нь Төлөөлөгчийг дэмжих сангийн хөрөнгөөр 43.9 сая төгрөгийн нормын хувцас, бичиг хэргийн болон сэлбэг хэрэгсэл худалдан

авч, өглөг дансанд орлого, зарлагаар бүртгэснийг залруулга хийж, бараа материалын дансанд орлого, зарлагаар зөвшөөрч залруулсан.

- Газрын тосны газар нь Уул уурхайн яамны холбогдох ажилтнуудын гадаад томилолт, шатахуун, хүлээн авалтын зардалд нийт 46.7 сая төгрөгийг өөрийн орлогоос санхүүжүүлсэн тул албан шаардлага хүргүүлсэн болно.
- Ашигт малтмалын газрын мөнгөн хөрөнгийн зарцуулалтыг шалгахад төсөл, арга хэмжээний зардлаас АМГ-ын 15 ажиллагсдыг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж 24.9 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, батлагдсан төсөвт зардлаас гадуур 6.1 сая төгрөгийг баяр ёслолын арга хэмжээнд гаргасан байна.
- Ашигт малтмалын газар нь УСНББОУС 1, 12-ын дагуу худалдах зориулалтаар дотооддоо бэлтгэсэн барааг бодит өртгөөр нь бүртгэлд тусгаагүй байна.
- Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлангийн Засгийн газрын оруулсан капитал данс тайлант хугацаанд 109.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Уул уурхайн яамны аппарат 195.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ Засгийн газрын санг нэмэгдүүлэн бүртгэсэн, Газрын тосны газар 2013 оны ТӨХ-ны 421 дүгээр тогтоолоор үндсэн хөрөнгийг данснаас хасахдаа 53.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 4 автомашиныг балансаас балансад шилжүүлсэн, 33.0 сая төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий 2 автомашиныг дуудлага худалдаагаар худалдаж, нийт 86.6 сая төгрөгийн үлдэгдэл өртөгтэй үндсэн хөрөнгөөр Засгийн газрын санг бууруулан бүртгэснийг УСНББОУС болон Сангийн сайдын 2013 оны 269 дугаар тушаалын дагуу аудитаар тус тус залруулсан болно.

Илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд

Мөнгөн хөрөнгийн талаар

УУЯ нь 1,618.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй бөгөөд үүнээс Төрийн сангийн дансанд 296.1 сая, арилжааны банкны дансанд 1,196.1 сая, нийт 1,492.2 сая төгрөгийг Сангийн яамтай тооцоо нийлэн баталгаажуулсан бол "Уул уурхайн бохирдлыг тогтоох", "Тогтвортой бичил уурхай" төсөл хөтөлбөрүүдийн үлдэгдэл 126.4 сая төгрөгийн үлдэгдлийг холбогдох арилжааны банкттай тооцоо нийлж, үлдэгдлийн баталгаа гаргаагүй байна.

Төсвийн төлөвлөлтийн талаар

2013 онд нийт төсвийн гүйцэтгэлээр цалин хөлс, НДШ-ийн зардал 81.1 сая, урсгал үйл ажиллагааны зардал 636.5 сая, хөрөнгийн зардал 1,262.0 сая, нийт 1,979.6 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн боловч гэрээт ажилчдын цалин, тэтгэврийн даатгал, ажилгүйдлийн даатгал, түлш халаалт, байрны түрээсийн зардал, багаж хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, гадаад томилолт, ном хэвлэл, сургалт, семинарын зардал, төлбөр хураамж болон бусад зардал, газрын төлбөр зэрэг зардлууд 0.08-93.4 сая төгрөгөөр батлагдсан төсөвт зардлаас хэтэрсэн байна.

Зориулалт бус зарцуулалтын талаар

Уул уурхайн яамны аппаратын батлагдсан төсөвт зардлаас зориулалт бусаар 20.4 сая төгрөгийг баяр ёслолын арга хэмжээ болон шагнал урамшуулалд зарцуулжээ.

Бараа материалын бүртгэлийн талаар

Уул уурхайн яамны аппаратын тайланд 2.7 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг бараа материалын дансанд бүртгэхгүйгээр шууд зардалд тайлагнасан байна.

Санхүүгийн тайлагналын талаар

Уул уурхайн сайдын төсвийн багцад 406.1 сая төгрөгийн төсөвтэй “Тогтвортой бичил уурхай”, “Уул уурхайн бохирдлыг тогтоох” 2 төсөл хөтөлбөр хэрэгжиж, гүйцэтгэлээр 365.6 сая төгрөгийг зарцуулсан ба уг төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан нь аудит хийгдээгүй санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Үндэсний аудитын газар аудит хийсэн ба уг аудитаар 7 зөвлөмж өгөгдсөнийг 80 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын санал дүгнэлт

Бид Уул уурхайн сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд “зөрчилгүй” санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210046 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 28-04-37, Факс: 32-32-66

2014.04.25 № 684

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Уул уурхайн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Уул уурхайн яамны удирдлага нь Төсвийн тухай хуульд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангуудыг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Уул уурхайн сайдын төсвийн багцын 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

070444

**УУЛ УУРХАЙН САЙДЫН
ТӨСВИЙН БАГЦЫН 2013 ОНЫ
САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1

Асуудал 1

Мөнгөн хөрөнгийн талаар

Асуудал 2

Төсвийн төлөвлөлтийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

Асуудал 3

Зориулалт бус зарцуулалтын талаар

Асуудал 4

Бараа материалын бүртгэлийн талаар

Асуудал 5

Санхүүгийн тайлагналын талаар

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ҮАГ-ын аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан. Энэ нь Уул уурхайн сайдын төсвийн багцын нягтлан бодох бүртгэлийн бодлого, тогтолцоо, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянах бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгаж байгаа болно.

Үндэсний аудитын газар энэхүү зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Р.Жигжид, ЭЗСХОХ-ийн дарга Н.Энхбаяр болон бусад санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

Асуудал 1 Мөнгөн хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

УУЯ нь 1,618.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлтэй бөгөөд үүнээс Төрийн сангийн дансанд 296.1 сая, арилжааны банкны дансанд 1,196.1 сая, нийт 1,492.2 сая төгрөгийг Сангийн яамтай тооцоо нийлэн баталгаажуулсан бол "Уул уурхайн бохирдлыг тогтоох", "Тогтвортой бичил уурхай" төсөл хөтөлбөрүүдийн үлдэгдэл 126.4 сая төгрөгийн үлдэгдлийг холбогдох арилжааны банктай тооцоо нийлж, үлдэгдлийн баталгаа гаргаагүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

НББ-ийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4:-д "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэснийг мөрдөж ажиллах;

Эрсдэл

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

2013 онд нийт төсвийн гүйцэтгэлээр цалин хөлс, НДШ-ийн зардал 81.1 сая, урсгал үйл ажиллагааны зардал 636.5 сая, хөрөнгийн зардал 1,262.0 сая, нийт 1,979.6 сая төгрөгийн зардлыг хэмнэсэн боловч гэрээт ажилчдын цалин, тэтгэврийн даатгал, ажилгүйдлийн даатгал, түлш халаалт, байрны түрээсийн зардал, багаж хэрэгсэл, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс, гадаад томилолт, ном хэвлэл, сургалт, семинарын зардал, төлбөр хураамж болон бусад зардал, газрын төлбөр зэрэг зардлууд 0.08-93.4 сая төгрөгөөр батлагдсан төсөвт зардлаас хэтэрсэн байна.

Эрсдэл

Төсвийн төлөвлөлт үндэслэлгүй хийгдэж, бодит бус хэтрэлт, хэмнэлт үүсэх;

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6.4.1-д: “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэснийг баримталж ажиллах;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Уул уурхайн яамны аппаратын батлагдсан төсөвт зардлаас зориулалт бусаар 20.4 сая төгрөгийг баяр ёслолын арга хэмжээ болон шагнал урамшуулалд зарцуулжээ.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг мөрдөж ажиллах;

Эрсдэл

Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын мөрдөлт хангалтгүй байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Уул уурхайн яамны аппаратын тайланд 2.7 сая төгрөгийн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийг бараа материалын дансанд бүртгэхгүйгээр шууд зардалд тайлагнасан байна.

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС-12 дагуу хөрөнгийн шинж чанартай бараа материалыг үнэлж, бүртгэлд тусгах;

Эрсдэл

Бараа материалын бүртгэл, УСНББОУС болон холбогдох заавар, журмын дагуу хийгдээгүй байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсан болно.

ҮАГ-ын ажиглалт

Уул уурхайн сайдын төсвийн багцад 406.1 сая төгрөгийн төсөвтэй “Тогтвортой бичил уурхай”, “Уул уурхайн бохирдлыг тогтоох” 2 төсөл хөтөлбөр хэрэгжиж, гүйцэтгэлээр 365.6 сая төгрөгийг зарцуулсан ба уг төсөл хөтөлбөрийн санхүүгийн тайлан нь аудит хийгдэлгүйгээр санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байна.

Эрсдэл

Санхүүгийн тайлагнал УСНББОУС болон холбогдох заавар, журмын дагуу хийгдээгүй байх;

ҮАГ-ын зөвлөмж

Төсөл хөтөлбөрийн санхүүжилт болон төслийн үр дүнг аудитаар баталгаажуулдаг байх;

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлагад танилцуулж, гарын үсэг зуруулсан болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Хөрөнгө	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	15,597,940,701.71	1,618,590,466.59
Авлага	12,734,726,614.87	28,498,187,254.88
Урьдчилгаа тооцоо	17,088,957,559.01	24,250,106,391.63
Бараа материал	719,748,719.52	738,727,300.16
Шатахууны нөөц	21,635,876,025.56	23,175,390,353.28
Эргэлтийн хөрөнгийн нийт дүн	67,777,249,620.67	78,281,001,766.54
Эргэлтийн бус хөрөнгө		
Биет хөрөнгө	10,376,138,628.43	17,377,048,642.29
Биет бус хөрөнгө	223,819,099.20	266,660,660.77
Эргэлтийн бус хөрөнгийн нийт дүн	10,599,957,727.63	17,643,709,303.06
Хөрөнгийн нийт дүн	78,377,207,348.30	95,924,711,069.60
Өр төлбөр		-
Өглөг	2,322,613,563.01	2,511,057,596.46
Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн	2,322,613,563.01	2,511,057,596.46
Өр төлбөрийн нийт дүн	2,322,613,563.01	2,511,057,596.46
Цэвэр хөрөнгө/өмч		
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ Орон нутгийн сан	19,884,970,752.94	19,884,970,752.94
Хуримтлагдсан үр дүн	55,381,544,919.94	72,743,681,107.79
Өмнөх үеийн үр дүн	55,381,544,919.94	55,365,491,313.95
Тайлант үеийн үр дүн		17,378,189,793.84
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	788,078,112.41	785,001,612.41
Цэвэр хөрөнгө/өмчийн нийт дүн	76,054,593,785.29	93,413,653,473.14
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн нийт дүн	78,377,207,348.30	95,924,711,069.60

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны орлого	-	-
Олон улсын байгууллагын тусламж	1,328,376,611.00	2,969,854,189.63
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,535,670,520.89	24,395,732,731.30
Хөрөнгийн санхүүжилт	782,024,225.00	1,202,365,122.00
Урьд оны төсвийн хөрөнгө оруулалт	-	-
Нэмэлт санхүүжилт	-	12,562,643.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,308,497.00	1,186,718.00
Газрын тосны орлого	121,856,373,805.64	189,637,548,410.70
Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого	26,620,464,737.25	49,175,663,108.10
Бусад орлого		216,585,943.20
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	163,124,218,396.78	267,611,498,865.63
Үндсэн үйл ажиллагааны зардал		
Цалин, хөлс болон ажиллагсдын тэтгэмж	3,853,921,109.69	5,056,537,812.24
Бараа үйлчилгээний зардал	3,092,034,261.62	7,309,028,273.62
Төвлөрүүлэх шилжүүлэг	102,481,244,759.53	234,043,093,858.08
Нийгмийн хамгааллын зардал	1,263,836,517.97	1,509,469,829.54
Хөтөлбөр арга хэмжээний зардал	3,817,123,051.29	1,876,877,470.79
Бусад зардал	100,802,015.38	811,976,826.12
Хөрөнгийн зардал	554,656,125.00	1,373,075,359.00
Үндсэн үйл ажиллагааны зардлын нийт дүн	115,163,617,840.48	251,980,059,429.39
Үндсэн үйл ажиллагааны нийт ашиг/алдагдал	47,960,600,556.30	15,631,439,436.24
Гадаад валютын ханшийн зөрүү олз	971,547,110.52	4,230,284,126.36
Үндсэн бус үйл ажиллагааны орлогын дүн	971,547,110.52	4,230,284,126.36
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	32,653,021.65	1,221,729,482.01
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	385,361,993.70	1,261,804,286.75
Үндсэн бус үйл ажиллагааны зардлын дүн	418,015,015.35	2,483,533,768.76
Тайлант үеийн үр дүн	48,514,132,651.47	17,378,189,793.84

АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/төгрөгөөр/

Үзүүлэлт	2012 оны 12-р сарын 31	2013 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
Хүлээн авсан мөнгөн хөрөнгө:		
Гадаад орнуудаас үзүүлсэн тусламж	1,328,376,611.00	1,829,612,182.23
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	12,535,670,520.88	24,177,490,494.00
Өр барагдуулах санхүүжилтийн орлого	2,143,423,515.73	
Хөрөнгийн санхүүжилт	782,024,225.00	
Урьд оны хөрөнгө оруулалт	-	
Нэмэлт санхүүжилт	-	12,720,643.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,308,497.00	1,186,718.13
Газрын тосны орлого	121,402,304,963.70	175,077,874,239.05
Төсөвт байгууллагын ажил үйлчилгээний орлого	48,228,514,312.19	45,774,689,557.53
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын нийт дүн	186,421,622,645.50	246,873,573,833.94
Зарцуулсан мөнгөн хөрөнгө:		
Цалин, хөлс болон ажиллагсдын тэтгэмж	3,852,003,234.18	5,267,886,571.38
Бараа үйлчилгээний зардал	2,098,264,484.10	7,246,156,038.49
Хөтөлбөр арга хэмжээний зардал	6,067,028,536.00	8,876,294,890.64
Төвлөрүүлэх шилжүүлэг	156,632,966,166.70	234,016,010,174.99
Нийгмийн хамгааллын зардал	1,283,563,499.97	1,520,696,173.27
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн хөрөнгийн нийт дүн	169,933,825,920.95	256,927,043,848.77
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	16,487,796,724.55	(10,053,470,014.83)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Биет болон биет бус үндсэн хөрөнгө худалдан авалт	1,028,791,697.40	5,837,224,062.06
Хөрөнгийн бусад зардал	422,024,225.00	1,373,075,359.00
Хөрөнгө оруулалтын мөнгөн зардлын дүн	1,450,815,922.40	7,210,299,421.06
Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ	(1,450,815,922.40)	(7,210,299,421.06)
Төлсөн зээл		3,439,994.60
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	560,959,899.56	3,287,859,195.37
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	560,959,899.56	3,284,419,200.77
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	15,597,940,701.71	(13,979,350,235.12)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		15,597,940,701.71
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,597,940,701.71	1,618,590,466.59

АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/ төгрөгөөр /

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2012 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл		-		
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	6,867,412,268.47	6,867,412,268.47
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	19,884,970,752.94	-	-	19,884,970,752.94
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		788,078,112.41		788,078,112.41
Тайлант үеийн үр дүн	-	-	48,514,132,651.47	48,514,132,651.47
2012 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,884,970,752.94	788,078,112.41	55,381,544,919.94	76,054,593,785.29
2013 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	19,884,970,752.94	788,078,112.41	55,381,544,919.94	76,054,593,785.29
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(16,053,605.99)	(16,053,605.99)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	19,884,970,752.94	788,078,112.41	55,365,491,313.95	76,038,540,179.30
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт			-	
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт		(3,076,500.00)		(3,076,500.00)
Тайлант үеийн үр дүн	-		17,378,189,793.84	17,378,189,793.84
2013 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	19,884,970,752.94	785,001,612.41	72,743,681,107.79	93,413,653,473.14

АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

2012 болон 2013 оны 12-р сарын 31-ээрх

/ төгрөгөөр /

Зардлын нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	15,470,559,663.61		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,035,110,500.00	20,055,480,022.91	1,979,630,477.09	91.02
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	22,035,110,500.00	20,055,480,022.91	1,979,630,477.09	91.02
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	10,191,310,500.00	9,473,638,729.91	717,671,770.09	92.96
Бараа, үйлчилгээний зардал	8,632,683,800.00	7,952,942,556.64	679,741,243.36	92.13
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,056,760,500.00	3,996,366,140.33	60,394,359.67	98.51
Үндсэн цалин	2,996,395,200.00	2,995,755,572.23	639,627.77	99.98
нэмэгдэл цалин	831,364,400.00	785,168,192.69	46,196,207.31	94.44
Унаа хоолны хөнгөлөлт	229,000,900.00	215,442,375.41	13,558,524.59	94.08
Нийгмийн хамгаалалын шимтгэл	453,143,600.00	432,419,745.55	20,723,854.45	95.43
Тэтгэврийн даатгал	287,273,300.00	317,728,283.39	(30,454,983.39)	110.60
Тэтгэмжийн даатгал	33,174,100.00	19,438,018.16	13,736,081.84	58.59
ҮОМШӨ-ний даатгал	41,467,700.00	31,372,992.73	10,094,707.27	75.66
Ажилгүйдлийн даатгал	8,293,300.00	8,384,369.48	(91,069.48)	101.10
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	82,935,200.00	55,496,081.79	27,439,118.21	66.91
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	4,122,779,700.00	3,524,156,670.76	598,623,029.24	85.48
Тогтмол зардал	427,769,200.00	384,824,509.07	42,944,690.93	89.96
Гэрэл цахилгаан	123,172,700.00	95,601,658.80	27,571,041.20	77.62
Түлш, халаалт	230,762,300.00	233,248,569.93	(2,486,269.93)	101.08
Цэвэр, бохир ус	73,834,200.00	55,974,280.34	17,859,919.66	75.81
Бараа, үйлчилгээний зардал	3,695,010,500.00	3,139,332,161.69	555,678,338.31	84.96
Бичиг хэрэг	65,788,200.00	57,299,670.00	8,488,530.00	87.10
Тээвэр (шатахуун)	202,071,600.00	186,265,004.00	15,806,596.00	92.18
Шуудан холбоо	81,482,000.00	67,706,962.81	13,775,037.19	83.09
Дотоод албан томилолт	279,879,700.00	141,774,001.02	138,105,698.98	50.66
Гадаад томилолт /арга хэмжээ/	103,199,300.00	196,561,372.70	(93,362,072.70)	190.47
Ном хэвлэл авах	1,500,000.00	2,791,264.00	(1,291,264.00)	186.08
Сургалт, семинарын зардал	-	80,000.00	(80,000.00)	
Эрдэм шинжилгээний ажил	30,000,000.00	15,000,000.00	15,000,000.00	50.00
Эд хогшил худалдан авах	83,417,200.00	66,858,768.00	16,558,432.00	80.15
Багаж хэрэгсэл	9,732,500.00	10,071,050.00	(338,550.00)	103.48
Тавилга	11,260,000.00	10,069,700.00	1,190,300.00	89.43
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,200,000.00	909,500.00	290,500.00	75.79
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	6,024,700.00	7,399,234.00	(1,374,534.00)	122.81
Программ	55,200,000.00	38,409,283.20	16,790,716.80	69.58
Нормын хувцас зөөлөн эдлэл	11,579,000.00	11,577,600.00	1,400.00	99.99
Эм	7,030,300.00	6,535,250.00	495,050.00	92.96
Урсгал засвар	87,091,300.00	79,554,447.25	7,536,852.75	91.35
Төлбөр хураамж болон бусад зардал	42,480,000.00	61,782,355.80	(19,302,355.80)	145.44
Гадаад зочны зардал	49,211,600.00	47,867,057.00	1,344,543.00	97.27
Биеийн тамирын уралдаан тэмцээн	4,500,000.00	3,254,230.00	1,245,770.00	72.32
Байрны түрээсийн зардал	29,170,800.00	40,915,501.00	(11,744,701.00)	140.26
Төвлөрсөн арга хэмжээ	8,000,000.00	7,994,370.00	5,630.00	99.93
Харуул хамгаалалтын зардал	20,030,000.00	17,700,000.00	2,330,000.00	88.37
Сургалт, хурал, зөвлөгөөний зардал	88,992,100.00	36,256,348.00	52,735,752.00	40.74
Давтан сургалтын зардал	22,107,100.00	714,400.00	21,392,700.00	3.23
Хичээл үйлдвэрлэлийн дадлага, сургалт	513,000.00	150,000.00	363,000.00	29.24

Төрийн албан хаагчийн мэргэшил дээшлүүлэх зардал	1,192,000.00	375,000.00	817,000.00	31.46
Гадаад сургалт, семинарт оролцох зардал	31,060,000.00	17,035,581.00	14,024,419.00	54.85
Сургалт семинар зохион байгуулах зардал	34,120,000.00	17,981,367.00	16,138,633.00	52.70
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамж	2,040,337,400.00	1,684,719,785.11	355,617,614.89	82.57
Төрийн өмнөөс гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	1,892,548,400.00	1,554,930,951.11	337,617,448.89	82.16
Аудит, зэрэглэл тогтоох үйлчилгээний хөлс (дотоод)	83,200,000.00	80,751,844.00	2,448,156.00	97.06
Эд хөрөнгийн даатгал	3,300,000.00	1,800,000.00	1,500,000.00	54.55
Тээврийн хэрэгслийн даатгал	10,020,000.00	8,785,390.00	1,234,610.00	87.68
Харуул, хамгаалалтын хөлс	51,269,000.00	38,451,600.00	12,817,400.00	75.00
Улсын мэдүүлэгийн маягт	2,400,000.00		2,400,000.00	-
Мэдээлэл сурталчилгааны зардал	50,750,000.00	41,325,764.00	9,424,236.00	81.43
Дотоодын эх үүсвэрээс санхүүжүүлж байгаа	406,100,000.00	365,512,411.00	40,587,589.00	90.01
Тагаас ба урсгал шилжүүлэг	1,558,626,700.00	1,520,696,173.27	37,930,526.73	97.57
Ажил олгогчоос олгох тэтгэмж, нэг удаагийн урамшуулал, дэмжлэг	166,802,000.00	130,444,196.13	36,357,803.87	78.20
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	61,681,200.00	37,925,250.00	23,755,950.00	61.49
Нэг удаагийн буцалтгүй тусламж	92,520,800.00	83,726,286.13	8,794,513.87	90.49
Шагнал, урамшил	12,600,000.00	8,792,660.00	3,807,340.00	69.78
Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж	1,365,000,000.00	1,363,870,465.14	1,129,534.86	99.92
Төлбөр, хураамж	26,824,700.00	26,381,512.00	443,188.00	98.35
Гэнэтийн ослын даатгал	20,324,700.00	15,900,000.00	4,424,700.00	78.23
Газрын төлбөр	6,500,000.00	10,481,512.00	(3,981,512.00)	161.25
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,843,800,000.00	10,581,841,293.00	1,261,958,707.00	89.34
Дотоод хөрөнгө оруулалт	4,279,000,000.00	3,596,840,458.00	682,159,542.00	84.06
Хөрөнгө оруулалт :Төсвийн хөрөнгөөр санхүүжих	3,027,000,000.00	2,452,700,000.00	574,300,000.00	81.03
Тоног төхөөрөмж : Төсвийн хөрөнгөөр санхүүжих	1,252,000,000.00	1,144,140,458.00	107,859,542.00	91.39
Геолог хайгуулын зардал	7,326,100,000.00	6,756,065,934.00	570,034,066.00	92.22
Төсөвт газрын их засвар	238,700,000.00	228,934,901.00	9,765,099.00	95.91
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	22,035,110,500.00	20,055,480,022.91	1,979,630,477.09	91.02
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,200,000.00	5,200,000.00	-	100.00
Төсвөөс санхүүжих	22,029,910,500.00	20,050,280,022.91	1,979,630,477.09	91.01
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,493,815,359.70		
Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын өөрчлөлт		13,976,744,303.91		
БАЙГУУЛЛАГЫН ТОО	6.00	6.00	-	
АЖИЛЛАГСАД БҮГД	399.00	399.00	-	
Удирдах ажилтан	31.00	32.00	(1.00)	
Гүйцэтгэх ажилтан	315.00	314.00	1.00	
үйлчлэх ажилтан	9.00	9.00	-	
Гэрээт ажилтан	44.00	44.00	-	